| 210204        | Ажилгүйдлийн даатгал   | 4,003,800.00            | 3,664,433.47            |
| 210205        | Эрүүл мэндийн даатгал  | 16,015,100.00           | 14,794,613.92           |
| <b>2103</b>   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>85,825,300.00</b>    | <b>85,825,120.00</b>    |
| 210301        | Гэрэл, цахилгаан   | 21,148,400.00           | 21,148,220.00           |
| 210302        | Түлш, халаалт  | 49,254,900.00           | 49,254,900.00           |
| 210303        | Цэвэр, бохир ус  | 15,422,000.00           | 15,422,000.00           |
| <b>2104</b>   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>26,157,800.00</b>    | <b>20,910,000.00</b>    |
| 210401        | Бичиг хэрэг  | 2,853,300.00            | 1,067,800.00            |
| 210402        | Тээвэр, шатахуун   | 19,574,300.00           | 16,513,600.00           |
| 210403        | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 3,730,200.00            | 3,328,600.00            |
| <b>2105</b>   | <b>Нормативт зардал</b>  | <b>683,200.00</b>       | <b>00.00</b>            |
| 210503        | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 683,200.00              | 00.00                   |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>6,540,400.00</b>     | <b>4,047,200.00</b>     |
| 210603        | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 494,600.00              | 00.00                   |
| 210604        | Урсгал засвар  | 6,045,800.00            | 4,047,200.00            |
| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>15,039,900.00</b>    | <b>12,422,800.00</b>    |
| 210702        | Дотоод албан томилолт  | 15,039,900.00           | 12,422,800.00           |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>22,554,200.00</b>    | <b>15,079,390.00</b>    |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,390,600.00           | 14,126,100.00           |
| 210803        | Даатгалын үйлчилгээ  | 346,000.00              | 169,290.00              |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар   | 225,000.00              | 00.00                   |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 34,000.00               | 00.00                   |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 728,300.00              | 580,000.00              |
| 210807        | Газрын төлбөр  | 830,300.00              | 204,000.00              |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>59,141,600.00</b>    | <b>57,840,546.00</b>    |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 59,141,600.00           | 57,840,546.00           |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>1,679,400.00</b>     | <b>-</b>                |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>1,679,400.00</b>     | <b>00.00</b>            |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 1,679,400.00            | 00.00                   |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,118,471,300.00</b> | <b>1,053,829,728.27</b> |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>1,005,684,600.00</b> | <b>1,040,050,827.27</b> |
| 132001        | Орон нутгийн төсвөөс   | 1,005,684,600.00        | 1,040,050,827.27        |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>112,786,700.00</b>   | <b>13,778,901.00</b>    |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 12,737,000.00           | 13,778,901.00           |
| 1200043       | Урьд оны үлдэгдлээс санхүүжих  | 100,049,700.00          | 00.00                   |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              | <b>00.00</b>            | <b>00.00</b>            |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             | <b>00.00</b>            | <b>00.00</b>            |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он              | Гүйцэтгэл             |
|-------------|---|-----------------------|-----------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b> |                       |                       |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                | <b>518,941,469.00</b> | <b>152,017,608.74</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                    | <b>518,941,469.00</b> | <b>152,017,608.74</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                  | <b>518,941,469.00</b> | <b>84,623,519.00</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                | <b>660,000.00</b>     | <b>-</b>              |
| 210105      | Гэрээт ажлын хөлс                                       | 660,000.00            | -                     |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | <b>82,500.00</b>      | <b>-</b>              |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                      | 82,500.00             | -                     |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>        | <b>1,000,000.00</b>   | <b>-</b>              |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,000,000.00          | -                     |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                 | <b>128,304,769.00</b> | <b>3,328,560.00</b>   |

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210401      | Бичиг хэрэг  | 93,853,080.00         | -                     |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 34,451,689.00         | 3,328,560.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>88,871,900.00</b>  | <b>-</b>              |
| 210604      | Урсгал засвар  | 88,871,900.00         | -                     |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>96,748,015.00</b>  | <b>10,742,627.00</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж   | 96,748,015.00         | 10,742,627.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>203,274,285.00</b> | <b>70,552,332.00</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 151,579,285.00        | 49,322,332.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 51,695,000.00         | 21,230,000.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>-</b>              | <b>67,394,089.74</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  |                       | <b>67,394,089.74</b>  |
| 213403      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг                              |                       | 67,394,089.74         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>518,941,469.00</b> | <b>152,017,608.74</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>518,941,469.00</b> | <b>152,017,608.74</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 435,336,113.00        | -                     |
| 131103      | ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,715,888.00         | 7,328,560.00          |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                 | 43,889,468.00         | 144,689,048.74        |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |                       |                       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |                       |                       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |                       |                       |

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 9,037.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 8,337.8 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд 1,278.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн
- Авлагыг 1,191,2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Өглөгийг 1,117.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Худалдан авсан 4, Аудитаар нийт 1,905,831.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,778,392.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>2</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй ирсэн 1,633,205.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг бүртгээгүй;
- Өр төлбөрийг санхүүгийн тайланд 26,245.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Нэмэлт санхүүжилтийн дансны орлого 626.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Үр дүнгийн тайланд орлогыг 69,914.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Орон нутгаас олгосон санхүүжилтийг 220.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Бүртгэлтэй 8,935.6 өглөгийг өмнөх үеийн үр дүн дансанд бууруулах бичилт хийсэн;
- ИТХ-аас 38,565.5 мянган төгрөгийн хөрөнгийг актлах тогтоол гарсан байхад хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй;
- Худалдан авсан 680.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгахгүйгээр шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 127,439.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 127,439.0 мянган төгрөгийн 6 зөрчил илэрч, 2,064.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 125,375.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилган давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн байна.

### **3.1 Төлбөрийн акт**

**3.1.1 Илрүүлэлт:** Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн барилгыг бусдад түрээслэн 5,160.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн ч орлогын 40 хувь болох 2,064.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-д “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 хувиар тогтоосугай” гэсэн заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоосон.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Байгууллагын нэр дээр кадастр гарсан газруудыг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн тайланд газрыг үнэлж бүртгэх ажлыг зохион байгуулах,

#### **3.2.2 Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд 110,621.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг өр төлбөрийн дансаар дамжуулахгүйгээр шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалын хавсралт 4-ын 3 дугаар бүлгийн 3.7-д “Тайлант хугацаанд хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дараах байдлаар бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн мөрдөн ажиллаж нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтөлж байх,

### 3.2.3 Анхан шатны баримттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд анхан шатны баримт дутуу 14,754.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:** Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох.

### 3.2.4 БАРАА МАТЕРИАЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

**Илрүүлэлт:** Бараа материалыг орлого авахдаа бөөн дүнгээр орлого авч зардалд бүртгэж байгаа нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын нярав нь бараа материалыг хүлээн авах бүрд орлогын баримт үйлдэн санхүүгийн тайланд бүртгэж зарлагдахдаа шаардах хуудсыг үндэслэн бүртгэж хэвших

### 3.2.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Шилэн дансны хуульд заасан байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 9 ажил гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 100,328.4 мянган төгрөгийн 12 ажил гүйлгээг мэдээлээгүй Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** shilendans.gov.mn цахим системд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга  | Нийт алдаа |                    | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                    | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс:    |                    |              |     | Зөвлөмж |     |
|-------------------------------------|---|------------|--------------------|-----------------------------------|--------------------|--------------------------|------------------|------------|--------------------|--------------|-----|---------|-----|
|                                     |   |            |                    |                                   |                    |                          |                  | Залруулсан |                    | Залруулаагүй |     |         |     |
|                                     |   | Тоо        | Дүн                | Тоо                               | Дүн                | Тоо                      | Дүн              | тоо        | Дүн                | тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| 1                                   | 2   | 3          | 4                  | 5                                 | 6                  | 7                        | 8                | 9          | 10                 | 11           | 12  | 13      | 14  |
| Алтай сумын ЗДТГ                    | Үнэгүй орлогыг дутуу илэрхийлсэн                    | 1          | 1,633,205.2        | 1                                 | 1,633,205.2        |                          |                  | 1          | 1,633,205.2        |              |     |         |     |
|                                     | Бараа материалыг шууд зардалд бүртгэсэн             | 1          | 680.0              | 1                                 | 680.0              |                          |                  | 1          | 680.0              |              |     |         |     |
|                                     | ИТХ-аар акталсан хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй | 1          | 38,565.6           |                                   |                    | 1                        | 38,565.6         | 1          | 38,565.6           |              |     |         |     |
|                                     | Үр дүнгийн тайланд орлогыг илүү илэрхийлсэн         | 1          | 69,914.0           |                                   |                    | 1                        | 69,914.0         | 1          | 69,914.0           |              |     |         |     |
|                                     | Өр төлбөрийг илүү илэрхийлсэн                       | 1          | 35,181.5           |                                   |                    | 1                        | 35,181.5         | 1          | 35,181.5           |              |     |         |     |
|                                     | Нэмэлт санхүүжилтийн орлогыг дутуу бүртгэсэн        | 1          | 626.5              | 1                                 | 626.5              |                          |                  | 1          | 626.5              |              |     |         |     |
|                                     | Орон нутгийн санхүүжилтийг илүү тайлагнасан         | 1          | 220.0              |                                   |                    | 1                        | 220.0            | 1          | 220.0              |              |     |         |     |
| <b>Нийт дүн</b>                     |   | <b>7</b>   | <b>1,778,392.8</b> | <b>3</b>                          | <b>1,633,885.2</b> | <b>4</b>                 | <b>143,881.1</b> | <b>7</b>   | <b>1,778,392.8</b> |              |     |         |     |

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга                                 | Нийт алдаа, зөрчлийн дүн |           | Үүнээс:       |      |                 |     |         |          |   |     |
|-------------------------------------|---|--------------------------|-----------|---------------|------|-----------------|-----|---------|----------|---|-----|
|                                     |   | Тоо                      | Дүн       | Төлбөрийн акт |      | Албан шаардлага |     | Зөвлөмж |          | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн |     |
|                                     |   |                          |           | Тоо           | Дүн  | Тоо             | Дүн | Тоо     | Дүн      | Тоо                                     | Дүн |
| 1                                   | 2   | 3                        | 4         | 5             | 6    | 7               | 8   | 9       | 10       | 11                                      | 12  |
| Алтай сумын ЗДТГ                    | Түрээсийн орлогын 40 хувийг төсөвт төвлөрүүлээгүй         | 1                        | 2,064.0   | 1             | 2064 |                 |     |         |          | 0                                       |     |
|                                     | Аккруэл сууриар бүртгэл хөтлөөгүй, шууд зардалд бүртгэсэн | 1                        | 110,621.1 |               |      |                 |     | 1       | 110621.1 |   |     |
|                                     | Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн         | 1                        | 14,754.0  |               |      |                 |     | 1       | 14,754.0 |   |     |

|  |  |          |                  |          |                |          |          |                  |          |          |
|--|--|----------|------------------|----------|----------------|----------|----------|------------------|----------|----------|
|  | Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрыг санхүүгийн тайланд тусгаагүй | 1        | -                |          |                |          | 1        | -                |          |          |
|  | Бараа материалыг бөөн дүнгээр орлого авч зардлаар бүртгэсэн          | 1        | -                |          |                |          | 1        | 0                |          |          |
|  | <b>Нийт дүн</b>  | <b>5</b> | <b>127,439.1</b> | <b>1</b> | <b>2,064.0</b> | <b>0</b> | <b>4</b> | <b>125,375.1</b> | <b>0</b> | <b>-</b> |

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга                                 | Нийт алдаа, зөрчлийн дүн |          | Үүнээс:       |          |                 |          |          |          |
|-------------------------------------|---|--------------------------|----------|---------------|----------|-----------------|----------|----------|----------|
|                                     |   | Тоо                      | Дүн      | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          |
|                                     |   |                          |          | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн      |
| 1                                   | 2   | 3                        | 4        | 5             | 6        | 7               | 8        | 9        | 10       |
| Алтай сумын ЗДТГ                    | Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй | 1                        | 0        | 0             | 0        | 0               | 0        | 1        |          |
|                                     | <b>Нийт дүн</b>   | <b>1</b>                 | <b>0</b> | <b>0</b>      | <b>0</b> | <b>0</b>        | <b>0</b> | <b>1</b> | <b>0</b> |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| А | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 |                         | 1              |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 |                         | <b>1</b>       |       |                            |